

“ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Нэг. Зорилго

“Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгасан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл нь хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэх, шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Арга зүй

“Төрийн албаны тухай” хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сангаар баталгаажуулж, хяналтад авсан.

Гурав. Хяналтын хамрах хүрээ

Эдийн засаг хөгжлийн яам, харьяа байгууллагууд “Оюуны өмчийн газар”, “Шинжлэх ухааны академи”, “Үндэсний шинжлэх ухаан технологийн сан”, “Үндэсний хөгжлийн хүрээлэн”, “Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн”, “Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн”, “Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн”, “Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн”, “Анагаах ухааны хүрээлэн”, “Шинжлэх ухааны паркийн захиргаа”, “Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн”, “Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв”-ийн 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, гүйцэтгэл

Байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт арга хэмжээг батлахдаа үйл ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй тоогоор баталсан байна.

4.1 Тайлант оны гүйцэтгэл

Тайлант онд 101 зорилтын хүрээнд 492 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс 83 хувь нь 85 буюу түүнээс дээш “Бүрэн хангалттай”, 17 хувь нь 70-85 хүртэл буюу “Хангалттай” үнэлэгдэж дунджаар 89.94 хувийн үнэлгээтэй байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалын дагуу газар тус бүрээр үнэлгээг гаргахад нийт дүнгээр 10 харьяа газар “Бүрэн хангалттай” /85%-100%/, 2 газар “Хангалттай” /70%-85%/ гэж үнэлэгдсэн бөгөөд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 100 хувь, Шинжлэх ухааны паркийн захиргаа 95.18 хувийн үнэлгээтэй гарч 2025 оны хэрэгжилтээр хамгийн өндөр үнэлгээтэй байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /89.9 хувь/

д/д	Байгууллагын нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Зарцуулсан төсөв /сая төгрөгөөр/	Дундаж Үнэлгээ	Байр
1.	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	8	21	1,373.5	100%	1
2.	Шинжлэх ухааны паркийн захиргаа	6	33	25.8	94.88%	2
3.	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	18	56	883.2	92.93%	3
4.	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	4	18	-	91.72%	4
5.	Оюуны өмчийн газар	6	23	-	91.72%	5
6.	Монгол улсын шинжлэх ухааны академи	11	72	-	91.60%	6
7.	Шинжлэх ухаан, технологийн сан	7	39	3,013.4	90.61%	7
8.	Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн	10	36	1,480.6	89.53%	8
9.	Анагаах ухааны хүрээлэн	12	48	502.6	88.44%	9
10.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв	5	50	74.2	87.94%	10
11.	Үндэсний хөгжлийн хүрээлэн	7	77	20.3	80.82%	11
12.	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	7	19	20.3	80.79%	12
НИЙТ		101	492	10,201.9	89.94%	

4.2 Зарцуулсан төсвийн хэрэгжилт

Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа байгууллагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт арга хэмжээний хэрэгжилтэд нийт 10.2 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Үүнээс бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга, хэмжээний хэрэгжилтэд 5.3 тэрбум төгрөг, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт арга, хэмжээний хэрэгжилтэд 4.1 тэрбум төгрөг, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг

хэрэгжүүлэх зорилт арга, хэмжээний хэрэгжилтэд 6.7 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан 3,013.4 мянган төгрөг буюу хамгийн өндөр төсөв зарцуулсан нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх шинжлэх ухааны эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үндсэн чиглэлийн болон суурь судалгааны төслийн санхүүжилтийг олгодог байна. Тус сан нь тайлант онд 15 гүйцэтгэгч байгууллагын үргэлжлэн хэрэгжиж байгаа 85 төслийн гүйцэтгэлд явцын үнэлгээ хийж санхүүжилтийг бүрэн олгожээ.

Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хэрэгжиж байгаа төслүүд нь улсын төсвөөс 201.1 сая төгрөгийн санхүүжилт авсан бол, гадаадын хөрөнгө оруулалтаар 860.0 сая төгрөг, өөрийн орлогоор 401.6 сая төгрөг нийт 1.4 тэрбум төгрөгөөр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд ихэвчлэн БНХАУ, Япон улсуудтай хамтарч төсөл хэрэгжүүлж, тэднээс өндөр хүчин чадал бүхий лабораторийн тоног төхөөрөмжийг хандив тусламжаар авах, эрдэм шинжилгээний ажилтнуудыг дээрх орнуудын зардлаар сургах, эрдмийн цол зэрэг хамгаалахад хамтарч ажилладаг байна.

Шинжлэх ухааны академи хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын лабораторийн барилгыг ашиглалтад оруулах, эрдэм Хакатон 2025 арга хэмжээ зохион байгуулахад, гарааны компанийг дэмжих,бойжуулах, төсөл хөтөлбөрт хамруулах, шинжлэх ухааны академийн хамтын оффисыг өргөжүүлэх хөгжүүлэх ,шинжлэх ухааны академийн үйл ажиллагаа үр дүнг сурталчлах, шинжлэх ухаан “Амьдрал” сэтгүүл, танин мэдэхүйн цуврал видео контент,архивын сан хөмрөг үүсгэх, залуу судлаачдыг мэргэшүүлэх сургалт, гадаад хамтын ажиллагаа, гадаад улстай хамтарсан судалгааны төсөлд чадавхжуулахад 2.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Тус хүрээлэнгүүдийн улсын төсвөөс санхүүжигдэх төслийн тоо хэмжээ харьцангуй бага байгааг харуулж байна.

Зарцуулсан төсөв зорилт арга хэмжээ тус бүрээр:

Д/д	Байгууллагын нэр	Зарцуулсан төсөв /сая төгрөгөөр/			
		Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Нийт дүн
1.	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	2,966.4	47.0	-	3,013.4
2.	Шинжлэх ухааны академи	1,567.9	1,027.5		2,595.4
3.	Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн	70.6	1,135.8	274.2	1,480.6

4.	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	93.0	1,229.5	51.0	1,373.5
5.	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	189.7	643.5	50.0	883.2
6.	Анагаах ухааны хүрээлэн	219.6	31.7	251.3	502.6
7.	Үндэсний хөгжлийн хүрээлэн	232.9			232.9
8.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв	19.5	18.5	36.2	74.2
9.	Шинжлэх ухааны паркийн захиргаа	14.0		11.8	25.8
10.	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	13.6	2.0	4.7	20.3
11.	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	-	-	-	-
12.	Оюуны өмчийн газар	-	-	-	-
	Нийт дүн	5,387.2	4,135.5	679.2	10,201.9

4.3 Тайлантай холбоотой гарсан асуудлууд:

Харьяа байгууллагууд хэрэгжилтийг хэт товч утгаар тайлагнасан, нотлох баримт хавсаргаагүй, зарцуулсан хөрөнгийг тусгаагүй, товчилсон үг хэрэглэсэн, зарим тохиолдолд гадаад үг хэллэг ашигласан зэрэг асуудлууд байна.

“Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн”, “Оюуны өмч”-ийн газрууд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.4.4-т “төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх” заалтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийг төлөвлөж тайлагнаагүй байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн төвийн зарим арга хэмжээний тайлагналт арга хэмжээнд хамааралгүй хэрэгжилт бичсэн, хэт товч тайлагнаж нотлох баримтаар баримтжуулаагүй, товчилсон үг их хэрэглэсэн, албан хэллэгээр бус ярианы хэллэгээр тайлагнасан байна.

Үндэсний хөгжлийн хүрээлэн 77 арга хэмжээний хэрэгжилт тайлагнаж, нотлох баримт хавсаргаагүй, төлөвлөлтөд төсөв тусгаагүй, хэрэгжилтийн зарцуулсан хөрөнгийг тайлагнаагүй байна.

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн нийт 19 арга хэмжээний 52.6 хувьд нь нотлох баримт хавсаргаагүй хэт товч утгаар бичсэн, хүрсэн түвшин үр дүнг тодорхойлж үгэн хэлбэрээр тайлагнаагүй, 47.4 хувьд нь нотлох баримт хавсаргасан боловч бүрдэл дутуу байх ба тайлагналт маш хангалтгүй байна.

Тав. Дүгнэлт

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 89.9 хувийн биелэлттэй гарсан бөгөөд нийт 12 харьяа газрын хэмжээнд 83 хувь нь “Бүрэн хангалттай”, 17 хувь нь “Хангалттай” гэж үнэлэгдлээ.

Нийт харьяа газрын 83.3 хувь нь “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.4.3 “шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх бөгөөд бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, салбарын мэдээлэлд үндэслэх, арга хэмжээний хүрэх түвшин нь зорилтын үр дүнг илэрхийлсэн байх” 2.4.4 “төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тусгасан байх” заалтын дагуу төлөвлөж, тайлагнасан байна.

Харьяа газруудын дундаж үнэлгээг гаргахад Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 100, Шинжлэх ухаан паркийн захиргаа 94.8, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн 92.9, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 91.7, Оюуны өмчийн газар 91.7, Монгол улсын шинжлэх ухааны академи 91.6, Шинжлэх ухаан, технологийн сан 90.6, Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн 89.5, Анагаах ухааны хүрээлэн 88.4, Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв 87.9, хувийн хэрэгжилттэй буюу “Бүрэн хангалттай” гэж үнэлэгдлээ.

Үндэсний хөгжлийн хүрээлэн 80.8, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 80.7 хувийн хэрэгжилттэй буюу “Хангалттай” үнэлэгдэж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 2.4.4 дэх заалтыг баримтлах, тайлагналыг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн холбогдох журмын дагуу төлөвлөлт тайлагналыг гүйцэтгэсэн. Хэрэгжилтэд зарцуулсан төсвийг улсын төсвийн, гадаадын хөрөнгө оруулалтаар, өөрийн орлогоос санхүүжигдсэн байдлаар тодорхой ангилж тайлагнасан **“САЙН ТУРШЛАГА”** байна. Нийт арга хэмжээний 22.2 хувь нь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй нь үнэлгээ буурахад нөлөөлж 89.5 хувийн үнэлгээтэй буюу журмын 2.5.1-р /85 буюу түүнээс дээш/ “Бүрэн хангалттай” үнэлэгдсэн байна.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал

- Тайлангийн утга найруулгыг хянах, хэт товч эсвэл хэт дэлгэрэнгүй тайлагнахгүй байх, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн тайлагнах;
- Хэрэгжилтэд хамаарах нотлох баримтыг хавсаргаж байх;
- Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг цахим системд сая төгрөгөөр гэж заасны дагуу тооны орон цифрийг зөв тоймлох;
- Хэт товч тайлагнасан тохиолдолд нотлох баримтыг бүрэн оруулж байх;
- Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг улсын төсвийн, өөрийн орлогын, гадаадын хөрөнгө оруулалт тус бүрээр салгаж тайлагнах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа байгууллагуудын
2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн
хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгын хавсралт

Д/ д	Байгууллагын нэр	Арга хэмжээний тоо	Үнэлгээ			Дундаж хувь
			85 буюу түүнээс дээш	70-85%	70 хүртэл	
1.	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	21	21	0	0	100.0
2.	Шинжлэх ухааны паркийн захиргаа	33	31	2	0	94.9
3.	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	56	37	18	1	93.0
4.	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	18	11	7	0	91.7
5.	Оюуны өмчийн газар	23	21	1	1	90.6
6.	Монгол улсын шинжлэх ухааны академи	72	63	9	0	91.5
7.	Шинжлэх ухаан, технологийн сан	39	26	11	2	89.1
8.	Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн	36	24	11	1	89.5
9.	Анагаах ухааны хүрээлэн	48	33	15	0	88.4
10.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв	50	28	17	5	87.9
11.	Үндэсний хөгжлийн хүрээлэн	77	28	46	3	80.8
12.	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	19	9	8	2	80.8
	Нийт	492	332	145	15	89.9